



British Embassy
Ulaanbaatar



**2009 онд бусдын нэр төр, алдар хүнд,
ажил хэргийн нэр хүндтэй холбоотой
шүүхээр шийдвэрлэсэн хэргийн талаарх
судалгааны тайлан**

Судалгааны зорилго

Иргэний болон Эрүүгийн хуулийн зохих зүйл заалтыг эрх мэдэлтэн, өндөр албантушаалтан, төрийн албан хаагч, төрийн байгууллага хэрхэн ашиглаж буйг илрүүлэхэд оршино.

Судалгааны хамрах хүрээ:

Монгол улсын

- Иргэний хуулийн 21, 27, 497, 511 дүгээр зүйлүүдэд нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг хамгаалах, учирсан гэм хорын хохирлыг арилгах,

- Эрүүгийн хуулийн 110 дугаар зүйлд доромжлох, 111 дүгээр зүйлд гүтгэх үйлдлүүдийг гэмт хэрэгт тооцохоор тус тус зохицуулдаг.

2009 оны хэргүүд

Монгол Улсын хэмжээнд 2009 онд нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд гутаасантай холбоотой 44, гүтгэлэг доромжлолтой холбоотой эрүүгийн нэг хэрэг бүх шатны шүүх, прокурорын байгууллагаар хянан шийдвэрлэгдсэн байна. Үүнээс

- Иргэний 17 хэрэгт сэтгүүлч, хэвлэл мэдээллийн хэрэгсэл бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан хэмээн хариуцагчаар татагдсан.

- Эрүүгийн хуулийн гүтгэх, доромжлохтой холбоотой зүйлээр сэтгүүлч, хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй холбоотой хэрэг шийдвэрлэгдээгүй байна.

Нутаг дэвсгэрийн хувьд

Сэтгүүлч, хэвлэл мэдээллийн хэрэгсэлд
холбогдох 17 хэрэг шийдвэрлэгдсэнээс

Улаанбаатар хотод 13 хэрэг

Сүхбаатар дүүрэгт - 9,

Чингэлтэй дүүрэгт - 3,

Баянгол дүүрэгт - 1

Орон нутагт 4 хэрэг


Завхан аймаг

Сэлэнгэ аймаг

Хэнтий аймаг

Орхон аймаг

2005-2009 онд шийдвэрлэсэн хэрэг



■ Нийт хэрэг ■ ХМХ-ын эсрэг ■ Эрүүгийн хэрэг ■ ХМХ-ын эсрэг.

Нэр төр сэргээх нэхэмжлэлтэй иргэний хэргийн тоо сүүлийн 10 жилийн дотор 2009 онд хамгийн олон гарсаныг харахад ийм төрлийн хэрэг цаашдаа ч өсөх хандлагатай байна.

Нэхэмжлэгчдийн бүрэлдэхүүн



2008 онд нэхэмжлэгчдийн 65 хувь нь эрх мэдэлтэн, төрийн өндөр албан тушаалтан, төрийн албан хаагчид байсан бол 2009 онд 73 хувь болж нэмэгдсэн



Хариуцагчдын бүрэлдэхүүн

Бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан нэхэмжлэлтэй шүүхээр шийдвэрлэгдсэн иргэний хэргүүдэд 13 сонин, нэг телевиз хариуцагчаар татагдсан байна.

Улаанбаатар хотод 10 сонин,

Орон нутагт 3 сонин, 1 телевиз тус тус хариуцагчаар татагджээ.

Улаанбаатар хотод гурван сонин тус бүр хоёр удаа хариуцагчаар татагдсан байна.

Шийдвэрлэсэн байдал

№	Шийдвэрлэсэн байдал	ХМХ-ийн тоо
1.	Нэхэмжлэл, гомдол гаргагч заргаа авсан	6
2.	Хариуцагч, холбогдогч ялсан	3
3.	Нэхэмжлэлээсээ татгалзсан	-
4.	Нэхэмжлэлийг хүлээн зөвшөөрсөн	6
5.	Харилцан тохиролцсон	2

Шүүхээр шийдвэрлэгдсэн иргэний 17 хэрэгт хариуцагчаар татагдсан ХМХ-үүдээс 6 сонин өмгөөлөгч авсан байна.

Завхан аймгийн “Завхан” сонинд холбогдох хэрэг анхан болон давж заалдах шат, хяналтын шатны шүүхээр хянан шийдвэрлэгдсэн.

Мөнгөн шаардлага

	ХМХ, сэтгүүлчээс нэхэмжилсэн		Төлүүлэхээр шийдвэрлэсэн	
	Дээд хэмжээ	Доод хэмжээ	Дээд хэмжээ	Доод хэмжээ
УБ хотод	20 сая	1 сая	2 сая 200 мянга	500 000
Орон нутагт	9 сая	500 000	250 000	200 000

Нэхэмжлэлийн мөнгөн шаардлагын хэмжээ, шүүхээс ногдуулж буй торгуулийн хэмжээ жил дараалан нэмэгдэж байна. 2008 онд торгуулийн хэмжээ нэг сая төгрөг байсан бол 2009 онд 2 сая 200 мянгад хүрсэн байна.

Дүгнэлт

1. 2008 онд нэр төр сэргээх хэргийн нэхэмжлэгчдийн 65 хувь нь эрх мэдэлтэн, төрийн өндөр албан тушаалтан, төрийн албан хаагчид байсан бол энэ тоо 2009 онд 73 хувь болж нэмэгдсэн нь Иргэний, Эрүүгийн хуулийн зохих зүйл заалтыг сэтгүүлчдийг айлган сүрдүүлэх, цензур тавихад ашиглах нь нэмэгдэж байна.

Торгуулийн доод хэмжээ Улаанбаатарт таван зуун мянган төгрөг, хөдөө орон нутагт хоёр зуун мянган төгрөг байгаа нь тухай ХМХ-ийн санхүүгийн байдалд бодитой хохирол учруулж болзошгүй байна. Иймд нэхэмжлэгчид хуулийн зүйл заалтыг эдийн засгийн бодитой цензур болгон ашиглаж байна гэж дүгнэхэд хүргэж байна.

Дүгнэлт

2. Ялагдсан сэтгүүлч, ХМХ-ийн тоо нэмэгдэж байна. 2008 онд иргэний хэргийн 71.4 хувьд шүүх ХМХ, сэтгүүлч буруутай гэсэн шийдвэр гаргасан бол 2009 онд энэ тоо 82.4 хувьд хүрчээ.

Энэ нь сэтгүүлч, ХМХ буруу ташаа мэдээлэл түгээж, бусдын нэр төрд халдсан мэт харагдавч, шүүх дээр ялалт байгуулахад нөлөөлж буй бодит хүчин зүйлүүд байж болох юм. **Нэгдүгээрт** тухайн хэрэг маргаанд ялагдсан тал болох сэтгүүлч, ХМХ нь давж заалдах шүүхэд хандахгүй байгаа нь бичиж нийтлүүлсэн материалын үнэн зөв болохыг нотлох үүрэг нь тэдэнд ногдож байгаатай холбоотой байж болох юм.

Хоёрдугаарт, хариуцагчаар татагдсан 17 сонины 11 нь өмгөөлөгчгүй, эрхлэгч, албаны дарга, сэтгүүлч нь шүүх хуралд оролцсон нь тухайн асуудалд эрх зүйн мэдлэгтэй оролцох соёл дутагдаж байж болох юм.

Дүгнэлт

Гуравдугаарт, хэвлэл мэдээллийн эрх зүйгээр мэргэшсэн хуульч, шүүгч, өмгөөлөгч дутмаг байгаа нь нөлөөлж байж болох юм.

Ялангуяа эрүүгийн хэрэгт авлига, зүй бус үйлдэл, нийгэмд бугшсан шударга бус явдлыг шүүмжлэн бичсэн сэтгүүлч, хэвлэл мэдээллийн хэрэгслийг яллахдаа тухайн нийтлэл, нэвтрүүлэгт дурьдагдсан асуудлыг шалгаж, нэр төрийг сэргээхийн оронд хэл зүйн шинжилгээ хийн дүгнэлт гаргаж шийдвэрлэж буй нь өрөөсгөл юм.

Ер нь шүүх олон нийтийн бодит эрх ашгийг бус нэхэмжлэгчийн эрх ашгийг дээдлэх үүднээс асуудалд хандан шийдвэр гаргаж байна гэж үзэж байна.

“Глоб Интернэшнл” ТББ

2011.05.02